

Оуэн Латтимор бол Монгол-Америкийн найрамдлын билэгдэл мөн

Э.Пунцаг

Өрнө, Дорнын боловсролыг хослуулан эзэмшсэн Америкийн эрдэмтэн профессор, 1987 онд Олон Улсын Монголч Эрдэмтдийн Ү их хурлаас Олон Улсын Монгол Судлалын Холбооны Ерөнхийлөгчөөр эцнээ сонгогдсон Оуэн Латтимор нь Монгол судлалаар 100 гаруй өгүүлэл, 20 гаруй ном бичиж туурвижээ. Энэ хурц ухаант эрдэмтний бүтээлд нанхиадаг болохоосоо Монгол судлал яах аргагүй давамгайлсан нь харагддаг. Тэрээр Монголын ард түмний уламжлалт түүх, соёлын түүхийг соргоогоор сонирхож, тухайн үеийн монголчуудын тэргүүний хэсгийн ардчилсан үзэл санааг талархан дэмжиж байсан нь түүний бүр 1930-аад оны зохиол бүтээлээс ажиглагддаг юм. 1935 онд бичиж “Азийн сэтгүүлд”-д нийтлүүлсэн “Нүүдэлчин байхын гамшиг” гэдэг өгүүлэлдээ монголчуудын нүүдлийн иргэншлийн онцлогийг шинжилж чухам монгол номадизм гэдэг юу вэ? гэсэн асуулт тавиад Монголд олон зууны турш жинхэнэ номадизм байсангүй. Манжийн эзэнт гүрний улс төрийн хэрэгцээ монголчуудын нийгэм, эдийн засгийн уламжлал хоёрын дундах зөвшөлдөөний үндсэн дээр байгуулагдсан нийгмийн хэлбэрийн дор аж төрж байв. Монгол аймаг, хошууд тус бүртээ тодорхой зааг хилтэй, нутаг дэвсгэртэй, тэр нутаг дэвсгэрээ тухайн хошуу нутгийнхан бүрэн эзэмшиж, чөлөөтэй нүүж байв, эс тэгвэл гандуу цаг уур нь малын бэлчээрт нэг дороо удаан байх боломжгүй байв. Хот хотоороо гусгай өвөлжөө, зуслантай боловч энэ нь газрыг хувьдаа өмчилж байгаа хэлбэр ч биш, “капиталист” маягаар монопольчилох ч биш, харин нутаг бэлчээрийг хамтарч, хуваарьтай ашиглаж байгаа хэлбэр гэж үзжээ.

Түүнчлэн, тайж ноёдын эрх мэдэл, эдлэн хөрөнгө нь ч боломжийн хязгаартай, тухайлбал тэд газрын эзэд ч биш, хошуу ардын хэмжээгүй эзэн ч биш байв. Ийм нөхцөлд ядуу

ноён ч байж болно, баян ард ч байж болно. Хэн байх нь тухайн хүний хөдөлмөр, ур ухаан, мэрийлт чармайлтаас шалтгаална. Жинхэнэ монголчуудын өөрсдөө байгуулсан нийгэмд иймэрхүү ардчиллын үр хөврөл багагүй байсан гэж тэмдэглэсэн байдаг.¹

Монголчуудын соёл иргэншил, аж төрөх ёсны талаархи О.Латтиморын судалгаа түүний урт амьдралын хугацаанд нэг ч удаа гажсангүй, нэг ч удаа тасарсангүй, харин ч улам гүнзгийрч ирсэн билээ. Зохиогчийн 1977 онд бичсэн “Тариачид, малчид, соёл” гэдэг өгүүлэлд “Олон зуун хөрш зэргэлдээ байсан хятадын соёл иргэншил, күнзийн сургаал нэвтрээгүй, тэр ч байтугай тариа, буудай гэх мэт газар тариалангийн нэр томъёо хятад бус, индо-европын гаралтай үг нэвтэрсэн, буддизм дэлгэрсэн нь Монголд энэтхэг-ираны соёл хятадынхаас илүү нөлөөтэй байсны гэрч, монголчууд биеэ даасан соёл иргэншилтэй байх бодлого явуулж байсны нотолгоо” гэж үзжээ.²

Оуэн Латтимор ийнхүү Монгол ба монголчуудад ойр дотно хандах болсон нь түүний жинхэнэ монголч эрдэмтэн болох үүд хаалгыг нь нээсэн байж боллох бөгөөд монголч эрдэмтний зам нь 1930-аад оны эхээр Өмнөд монголоос эхэлсэн түүхтэй юм. Гэвч эрдэмтний үзэл санааны төлөвшилд нийт монгол туургатны түүх, соёл, улс төр, эдийн засаг чухал үүрэг гүйцэтгэсэн нь мэдээж ээ.

Тэрээр зөвхөн Монголоор барахгүй нийт монгол туургатны оршин суугаа нутаг орноор дахин дахин аялан явж судалгааны ажлаа байнга шинэ мэдээ, мэдлэгээр сэлбэн баяжуулж байв. Монголд бол хойд тал нь Хөвсгөл далай, өмнөд тал нь Өмнөговь, Говь гурав сайхан гэх мэт олон аймаг, сумдыг мэдэх болсноос гадна Зөвлөлтийн ШУА-ийн (хуучин нэрээр) урилгаар (1970) Улаан-Үд, Уулын Алтай, Тува нутгаар аялсан аж. Ялангуяа Уулын Алтай, Тува нутгаар лав л Оросын хувьсгалаас хойш хүрч очсон анхны америк ажээ. О.Латтимор манай улсын нутаг дэвсгэр дээр анх хөл тавьсан нь 1944 он боловч монголчуудтай танилцаж эхэлсэн нь бүр 1920-иод оны дундуур юм. Тэрээр ийм танилцалтаа өвөр монголчуудаас эхэлсэн бөгөөд Хятадад байх хугацаандаа бас халх

монголчуудын төлөөлөгчтэй уулзаж танилцах завшаан тохиолдсон байх юм. тэр бол монголын шашин, төрийн томоохон төлөөлөгчийн нэг болох Дилав хутагт Жамсранжав билээ. Эцэг Латтимор, хутагт нарын нөхөрлөл тийнхүү 1930-аад оны гүүрүүчээр эхэлсэн бол хүү Давид Латтимор нь Дилав хутагттай нэгээс зургаан нас хүртлээ Хятадад, дараа нь 18 настайгаасаа хутагтыг өөд болон болтол АНУ-д садан төрлийн мэт ойр дотно хэлхээ холбоотой явж ирсэн байна. Давидад нь Батбилэг гэдэг монгол нэрийг Дилав хутагт хайрласан ба Батбилэг ч ойндоо хүрэхтэй үгүйтэй мөлхөж байхдаа дилав хутагтыг гэртээ ирэх дээр “ми-ний Буд-да”, “Ми-ний Буд-да” гэж угтаж очдог байсан. Дилав хутагт ч хүүхдэд их хайртай, тийм ч учраас 1949 онд хутагтыг Хятадаас Лхас руу гарах урилгатай байхад нь таныг Батбилэг санаад байна, юу ч гэсэн эхлээд нааш хүрч ирнэ үү гэж Дилав хутагтыг АНУ-д урьж өөрөө захирал нь байсан Жон Хопкинсийн Их сургуулийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн дэргэд байлгаснаар хутагт үлдсэн бүх насаа АНУ-д ажиллаж амьдарч өнгөрөөжээ. Тийнхүү Дилав хутагт, Хангин Гомбожав, Онон Өргөнгөө, тэдгээрийн гэр бүлийнхэн нийлж Латтиморынхантай хөршилснөөр монгол судлалын нэгэн бяцхан боловч чадварлаг хэсэг бүрдэж улмаар Х.Гомбожав, О.Өргөнгөө нар АНУ-д нэрт эрдэмтэд болсныг Оуэн Латтимор дурсан бичдэг. Харамсалтай нь профессор Х.Гомбожав “Монгол-англи хэлний толь” зэрэг олон тооны үнэт бүтээл туурвиж дэлхийн монгол судлалд дорвитой хувь нэмэр оруулсан хэдий ч ануухан насандаа Улаанбаатар хотноо хүнд өвчний улмаас нас барж АНУ-ын төрийн далбаагаар шарилаа бүтээлгэж монгол нутаг Алтан өлгийдөө үүрд нойрссон билээ.

Тийнхүү өвөр монголын үндэсний үзэлт, тэргүүний сэхээтэн Х.Гомбожав, О.Өргөнгөө, халхын АНУ-ыг талархагч улс төр, шашны томоохон зүтгэлтэн Дилав хутагт Жамсранжав зэрэг хүмүүсийг АНУ-д аваачиж хийдийн тэргүүн болон их сургуулийн профессор болтол өсгөж өндийлгөсөн ачтан нь Оуэн Латтимор ажгуу.

О.Латтимор явсан газар болгондоо хуучин, шинэ олон танилтай бөгөөд эгэл жирийн малчин, тариачнаас авхуулаад

эрдэмтэн, сэхээтэн, нам, төрийн удирдагчидтай хүртэл уулзаж санал бодлоо солилцдог байсан хүн. Манай улсад гэхэд л эрдэмтдээс академич Б.Ширэн-ов, Б.Ринчин, Ш.Лувсанвандан, Ц.Дамдинсүрэн, Ш.Нацагдорж, Ш.Бира, Н.Содном зэрэг олон хүмүүстэй аль хэзээнээ танил, тэдний зохиол бүтээлтэй уншиж танилцсан хүн байлаа.

Латтимор гуайн тийм танилын нэг болох Монголын ШУА-ийн сурвалжлагч гишүүн, тухайн үедээ НҮБ-д суух монголын байнгын төлөөлөгчийн алба хашиж байсан Ц.Пунцагноров гуай Үнэн сонинд нийтлүүлсэн “Монгол-Америкийн харилцаа” гэдэг өгүүлэлдээ БНМАУ-тай дипломат харилцаа тогтоох, түүнийг НҮБ-д элсүүлэх тухай асуудал АНУ-ын олон нийтийн анхаарлыг татах болсны үрээр АНУ-д монгол судлал түргэн хөгжиж эхлэв. Монгол судлалыг АНУ болон өрнө дахинд хөгжүүлэхэд америкийн гарамгай монголч эрдэмтэн О.Латтимор асар их үүрэг гүйцэтгэсэн билээ. О.Латиморын санаачилгаар Индианы Их сургууль байрладаг Блумингтон хотод “Монгол нийгэмлэг” байгуулагдаж манай улсын тухай эрдэм шинжилгээний мэдээлэл сэтгүүл гарах болов гэж тэмдэглэсэн байх юм. 3

Пунцагноров гуай мөн өгүүлэлдээ Монгол, Америкийн хооронд амьд холбоо тогтооход Дилав хутагт томоохон хувь нэмэр оруулсан юм гээд Жалханз хутагт Дамдинбазар, Дилав хутагт Жамсранжав зэрэг хүмүүс Монголоос алс хол оршдог, хүчирхэг Америк улсыг түшиглэх санал гаргахад Богд хаан түүнийг дэмжсэн ба 1920 онд Нийслэл хүрээнд дараа дараагаар хүрэлцэн ирсэн Америкийн дипломат Эберхардт, Сокобин нартай дээрхи хоёр хутагт Богд хааны даалгавраар уулзаж Монгол улсыг сэргээхэд АНУ-ын дэмжлэгийг хүссэн тухай дурдсан байна.

Баримт сэлтээс үзвээс хаалганд сууж байсан америкийн консул Эберхардт, Америкийн худалдааны Андерсен-Мэйер фирмийн төлөөлөгч Франз Ларсоны хамт Хүрээнд ирэхэд гардуулсан гадаад монголын автономийг сэргээх тухай Богдын бичгийн эхийг Жалханз гэгээн, Дилав хутагт хоёр бусад цөөн хүний хамт шөнөжин сууж бэлтгэсэн

бөгөөд Америкийн өөр нэгэн төлөөлөгч Сокобинд Богдын бичгийг гардуулахад Дилав хутагт зуучилжээ.4

Дашрамд дурдахад халхын тамга барьсан П хутагтын нэг Дилав хутагтын хойд дүр АНУ-ын харьяат халимаг монголчуудын үр сад дотроос тодорч тэрхүү тодорсон гэгээн Ү1 Дилав хутагт Данзанламид урьд дүрийнхээ уугуул нутаг Улиастай Завханаар 1991 оны намар морилсон зэргээс ургуулан бодоход Пунцагноров гуайн нэрлэсэн Америк, Монголын “амьд холбоо” тасралтгүй бэхжих сайн ерөөлтэй ажээ.

О.Латтимор 1978 онд Улаанбаатарт ирэхдээ Парист байгуулсан “Латтиморын Монгол судлалын институт” гэдэгтээ Ф. Исоногийн хамт ажиллаж байна, цаашдаа Парис, Английн Оксфордын Их сургууль хоёрын нэгд суурьшина, мэргэжлийн талаар бол хятад судлалыг орхилоо, харин монгол судлалыг орхиогүй. Тэтгэвэрт гараад 8 жил болж байгаа боловч монгол судлалаар мэр сэр юм хийж байна. “Нүүдэлчид ба хувьсгалчид” номынхоо хоёр дахь хэвлэлийг шинэ бүлэг нэмж гаргана. Дилав хутагтын намтрыг 1979 онд хэвлүүлнэ. Итали улсад хийгдэж буй түүхийн нэвтэрхий толь бичгийн захиалгаар түүнд орох монголын тухай өгүүллийг бичиж байна. Ж.Самбуугийн “Малчдад өгөх зөвлөгөө” номыг англи хэлнээ орчуулж оршил бичээд АНУ-д 1979 онд хэвлүүлнэ гэж байсан. Эдгээрийн олонхи нь ёсоор биелэгджээ.

О.Латтимор тэр жил өөрийн намтар, дурсамжийг бичиж байгаа бөгөөд тэгэхэд 20 нас буюу 1920 он хүртэлх үеийнхнийг бичээд байгаа, цаашид гүйцээж хэвлүүлэх, түүнд Монголын холбогдолтой зүйл нэлээд гарна гэж ярьж билээ. Үүнийг бичигч бээр тэр үед ШУА-ийн Дорно дахины хүрээлэнд ажиллаж байхдаа О.Латтимор гуайд үйлчилж улмаар танилцах завшаан тохиолдсон юм. Дээрх дурсамжийн номыг О.Латтиморын хамтран зүтгэгч, монголч эрдэмтэн Исоно Фужико өөрийн хичээнгүй хөдөлмөрийн үр дүнд О.Латтимор “Хятад ба би” /Токио, 1994/ нэртэйгээр хэвлэн гаргасан нь ихэд буянтай үйлс болжээ. Исоно Фужико багшийнхаа амьд сэрүүн ахуйд Парис, Кембриж хоёрын

хооронд хоёр жилийн турш аялж, 30 цагийн хуурцаг бичлэг хийсэн, хуучин архивтай нь танилцсан зэргээс үзэхэд уг ном О.Латтиморын 70-80 жилийн үйлс хөдөлмөрийн түүх, ирээдүйн Латтимор судлалд чухал хувь нэмэр болох нь дамжиггүй.

О.Латтимор Хятадад бага ба идэр насаа өнгөрүүлсэн Америкийн дээрээсээ нэгд орох хятад судлаач мэргэжилтэн, Хятадад АНУ-ын Ерөнхийлөгч Рузвельтийн хүсэлтээр Чан Кайшигийн зөвлөх, мөн нутагтаа генерал Маршаллын зөвлөх зэрэг олон янзын ажил алба хашиж явахдаа сайн, муу олон нэр авч, муу, сайн үг их сонсож явсан боловч харин Монголд Ла багш гэдэг ганц л нэртэй байсан хүн. Жирийн судлаачаас авхуулаад жинтэй академичид хүртэл Латтимор гуайг Ла багш гэж хүндэлдэг хүн Монголд одоо ч олон байна.

О.Латтимор манай хоёр хөршийн хэлийг сайн мэдэхээс гадна монгол хэл бичгийг нэвтэрхий сурсан бөгөөд анх заалгахдаа хятадын соёлд уусаагүй монгол хүнээр багшлуулахыг эрмэлзэж байсан, тэгээд ч миний багш бол жирийн малчин монгол хүн гэж ярьдаг байв. Түүгээр барахгүй АНУ-ыг талархагч халхын Дилав хутагт Жамсранжав мэт улс төр, шашны зүтгэлтэн, Өвөр монголын үндэсний үзэлт сэхээтэн хүмүүсийг АНУ-д аваачиж эрдэмтэн профессор болтол өсгөж өндийлгөсөн ачтан ажгуу. Тэрээр өвөг эцэг нь Америкийн Ерөнхийлөгч асан Абрам Линкольнтай гэр бүлийн шугамаар хамаатан садны холбоотой байсан учир эрдэмтэн эцгээ дагаж нэг настайдаа Хятадад ирснээс хойш Ази, дорно дахин, түүний дотор Монголын түүх, соёлыг биширч тууштай судалсан өрнөдийн цөөн эрдэмтний нэг юм. Монголд ирэх болгондоо О.Латтимор хөдөө орон нутгаар аялах дуртай бөгөөд ер нь хөдөө нутаг, малчдын амьдралыг гойд мэддэг, түүнд дассан болохоор тэр зүг татагдаад байдаг болов уу гэж бодогдоход хүргэнэ. түүний 1961 онд Монголд гэргийн хамт ирэхдээ Монголын хөдөөгөөр аялсан тухай өөрийн нь зохиолоос дараахи жижигхэн хэсгийг иш татъя. Түүнд дурдсан нь: нэг үйлдвэрээр ороод гарахдаа дор хаяж хөдөлмөрийн нөхцөл нь сайн, мууг гадарлаад гарч чадна. Олон жилийн өмнө Хятад газар даатгалын залуухан төлөөлөгч

явахдаа олсон туршлагын нэг тэр билээ. Гэвч миний малчин амьдралын туршлага хавьгүй дөнгүүр. Би ганц хонь, ганц тэмээ хараад л сүргийн тарга хүч, жингийн цувааны байдал зэргийг хэлж чадна гэж боддог. 1920-иод, 1930-аад онд хуучин Монголоор олон сар тэмээн аялал хийж явсан болохоор би хөдөө явж одоо үгийн монголчуудын мал аж ахуйн арга ажиллагаатай танилцах дур их байлаа. Тэгтэл ч ШУА-ийн түүхч нөхөд маань ашгүй Улаанбаатараас баруун ба баруун хойш чиглэлийн аймгуудаар 12 хоногийн аялал зохиох зөвшөөрөл олж баярлууллаа гэж бичсэн нь бий.

Тэрээр Архангай нэг нэгдлийн төвд өрөө модон байшинтай нэг айлд бууж цайлах зуур гэрийн эзэгтэйгээс байшин, гэр хоёрын аль нь тохиромжтой талаар ярилцсан дээрээ үндэслэж монголчууд байшин саванд амьдарч “суурьших” тусмаа гэрийн нөхцөлд хатгаа зэрэг амьсгалын замын өвчин авах нь амархан гэж хэлэх дуртай бололтой. Миний бодоход ийм санааг тэд оросуудаас авсан байх, энэ бол буруу юм. Монгол гэр өвөлд амархан дулаацдаг, агаарын солилцоо сайн, хаяаны манаас сайн бол нэвт шувт салхилахгүй таатай сайхан сууц. Би Монголд өвөлжиж байгаагүй бооловч урьд Өвөр Монголд байхдаа байшингаас байн байн ханиад авч байснаас гэрт нэг ч удаа ханиад тусаж байгаагүй гэсэн байх жишээтэй. Латтимор гуайн амьдрал аяллын энэ мэт жишээ олныг дурдаж болох нь мэдээж.

О.Латтимор, би бол онолоор бичдэггүй, практикаас үзсэн мэдсэн зүйлээ бичдэгээрээ бусад түүхчдээс ялгаатай, миний багш бол жирийн монгол, малчин хүн юм. Би Хөх хотоос Үрэмч хүртэл тэмээн жингээр аялсан хүн гэж хуучилдаг байв.

Тэрээр 1969 онд Монголын ШУА-ийн гадаад гишүүнээр сонгогдож, 1977 онд төрийн дээд шагнал “Алтангадас” одонгоор шагнагдсан юм. Тийнхүү Ардын засгийн үед АНУ-аас монголын төрийн дээд шагналаар энгэрээ мялаалгасан анхны хүн бол Оуэн Латтимор гуай билээ.

ОУМСХ, Монголын ШУА-иас хамтарч профессор О.Латтиморын мэндэлсний 90 жилийн ойг 1990 оны 7 дугаар сарын 25-нд Улаанбаатарт тэмдэглэсэн хурал дээр ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, академич Ш.Бира “Профессор Латтимор Өвөр Ази ба Монголыг судлагч”, Ц.Пунцагноров агсан /ШУА-ийн сурвалжлагч гишүүн/ “Монголын тусгаар тогтнол, Монгол ба АНУ-ын харилцаа: профессор Латтиморын үзэл баримтлал” гэдэг сонирхолтой илтгэлүүд тавьж профессор О.Латтиморын дэлхийн монгол судлалд оруулсан хувь нэмрийг өндөр үнэлсэн юм. Дорно дахин ба монголын судлалд бүтээлч амьдралынхаа 60 гаруй жилийг зориулсан энэ эрдэмтний талаар сурвалжлагч гишүүн Ц.Пунцагноров илтгэлдээ: “АНУ-Монголын ард түмний найрсаг харилцаа өөрчлөлт шинэчлэлтийн эрхн үед хэрэгжин биелэж байна. Тийнхүү манай хоёр орон элчин сайдын яамдаа тус тусынхаа Нийслэлд нээн ажиллуулснаар эдийн засаг, соёл, шинжлэх ухааны салбарт бидний хамтран ажиллах улам өргөн бололцоо хэн хэнд маань олдох болно” гэж цохон тэмдэглэж билээ.

Мөн хурал дээр Оросын нэрт монголч эрдэмтэн М.И.Гольман профессор О.Латтиморын талаар ярьсан яруу сайхан дурсамжиндаа: “Би түүнтэй Москва, Монгол, Монголын нийслэл Улаанбаатар, хөдөө тал нутаг гэх зэрэг олон газар таарч байсан юм... Хөдөө орон нутагт энгийн ард түмэнтэй кутгалдаж эх хэлээр нь харилцан ярилцаж байхад нь хүртэл уулзаж хуучилдаг байж билээ. Ер нь Ла багш монголч эрдэмтнийхээ судар түүхийг тийм замаар л эхэлсэн хүн дээ гээд...бид түүнийг өрнөдийн монгол судлалын өтгөс томчуулын тоонд зүй ёсоор оруулдаг юм. Тэрээр өрнөдийн монгол судлалын үүсэл хөгжилд нэр их хүчин чармайлт гаргаж энэ зорилгоо 30-40-өөд оны эхээр ч... 50-иад оны үед ч... ихээхэн анхаарч байв. Түүний гараар Америкийн Д.Фритерс, Ж.Флетчер, Английн Д.Притчатт, Каролина Хэмфри, Японы Фужико Исоно, Францын Р.Амайон, Д.Дюма, монгол үндэстэн Хангин Гомбожав, Онон Өргөнгөө нарын зэрэг янз бүрийн үндэстэн ястан олон тооны нэрт монголч эрдэмтэд хүмүүжиж өсч өндийсөн юм. Түүний эдгээр үйл ажиллагаа нь

дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдөж АНУ, Англи, Франц эдгээр гурван том орны монгол судлалын төвүүдийн хүндэт ерөнхийлөгчийн сонгуулийг өөд болон болтлоо хүлээж хүчин зүтгэсээр байв. Түүнчлэн ОУМСХ-ны анхны ерөнхийлөгч байлаа” гэж дурсан тэмдэглэжээ.⁶

Нью-Йоркт Дилав хутагтыг 1964 онд нас барах үед О.Латтимор Англид сууж байсан бөгөөд Дилав хутагт муу байна гэсэн мэдээг хүү Батбилэгээс авч тэр даруй зориуд ирж Ази, Америктай 30 гаруй жил ажил үйлсээ холбож ирсэн хүнтэйгээ амьд сэрүүнд нь уулзаж, оршуулах ёслолд нь оролцсон байх юм. Энэ дашрамд дурдахад О.Латтимор гуай 1989 онд АНУ-д өөд болоход Англиас түүний үнэнч шавь О.Өргөнгөө хүрэлцэн очиж оршуулах ёслолд нь оролцсон бөгөөд тэрээр “Ла багш насан эцэслэх дээрээ чандрынхаа хэсгээс Монгол нутагт, болбол бүр Говь гурван сайхан ууланд өргүүлэхийг хүсдэг байсан” гэж дурсан бичсэн буй.

Латтимор гуай манай улсын гадаад харилцааг ч ихээхэн гярхай гадарлан бичиж байв. Тэрээр “Нүүдэлчид ба комиссарууд” номдоо: биеэ даасан түүхтэй монголчууд ЗХУ, коммунист Хятад хоёрын дунд аль нэгийг нь түших сонголт хийж оршихыг хүсэхээ байв. Нэг хөрштэйгээ нийлж нөгөөтэйгээ үл эвлэрэх үзлээр өрсөлдөн тэмцэлдүүлэхийг тэд яахан хүсэх билээ?.

Дэлхийн бусад хэсгийн хувьд гэвэл Монголчууд Америкийг дэлхийн бусад аль ч орноос илүү шохоорхон сонирхож байна. АНУ-тай дипломат болон эдийн засаг, соёлын харилцаа тогтоох боломжийн талаар гэргий бид хоёртой олон монголчууд их уриалгахан ярьж байсан юм. Зөвхөн шинжлэх ухаан, техник аж үйлдвэрээр зогсохгүй өөрсдийнхөө онцгой түүхэн ажил амьжиргаа болох мал аж ахуйгаа эрхлэн хөгжүүлэх талаар ч биднээс сурч мэдэх юм их байгаа гэдэгт тэд бүрэн итгэлтэй байна гэж 32 жилийн тэртээ буюу 1962 онд хэвлүүлсэн “Нүүдэлчид ба комиссарууд” гэдэг номдоо бичсэн байдаг. /Номын 133 дахь тал/.

Энэ мэт тэр үед хэн ч хаана ч төдийлөн хэлж байгаагүй санаа оноо дэвшүүлж хашир эрдэмтний холч ухаанаар тавьсан оношоо “цаг үе харуулна” гэж байсныг түүнийг өөд болсноос

тавхан жилийн дараа өнөөгийн “цаг үе” нэгэнт харууллаа. Үнэхээр ч зөвхөн хөдөө аж ахуйн салбарт гэхэд л бүрэн хүч чадлаараа жилд 600-700 тонн ноос, ноолуур цэвэрлэх боломжтой монгол-америкийн хамтарсан ямааны ноолуур, гэмээний ноосны хялгас ялгаж цэвэрлэх “Монгол-Амикайл” үйлдвэр 1993 онд байгуулагдан үр ашигтай ажиллаж бас Монгол-АНУ-ын хамтарсан ноолуур боловсруулах “Монфорта” үйлдвэр байгуулагдаж 1994 оны 7 дугаар сараас үйлдвэрлэлээ эхэлсэн зэрэг нь эрдэмтний бодол санаа талаар өнгөрөөгүйг гэрчилж байна. Тийнхүү монголчууд энэ төрлийн технологийг саяхан хүртэл холын, одоо бол ойрын Америкаас анх сурч нэвтрүүлж буйг О.Латтимор бүр манай нийгэм, эдийн засгийн хуучин тогтолцооны үел л зөгнөж мөрөөдөн бичсэн байжээ.

Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын хооронд дипломат харилцаа тогтоосноос хойш өнгөрсөн 10 жилд, ялангуяа 1990 онд Монголд ардчилсан хөдөлгөөн өрнөж нэг намын дарангуйллыг олон намын тогтолцоот парламент, зах зээлийн эдийн засагт шилжих дэглэмээр сольсноос хойш хоёр орны улс төр, эдийн засаг, соёлын зэрэг төрөл бүрийн харилцаа, хамтын ажиллагаа идэвхитэй хөгжин гүнзгийрч байгаа нь АНУ-ын гарамгай монгол судлаач эрдэмтэн профессор Оуэн Латтиморын нэг мөрөөдлийн биелэл даруй мөн гэлтэй.

Их эрдэмтний мэндэлсэний 100 жилийн ой 2000 онд болох учир түүний наана манайд Латтимор судлалыг бий болгож, бусад зохистой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх талаар одооноос бодох нь зүйтэй болов уу.

Ишлэлийн хэлхээс

1. The voice of Ulanbator. November 1992, California.
2. Equipe e'cologie et anthropologie des Societe's pastorals: Pastoral production and Society. Maison des Sciences de l'Homme and Cambridge University Press, 1979. Printed in Great Britain.
3. “Үнэн” 1993.12.29.
4. The Dilav Khutagt. Memoris and Autobiography of a Mongol Buddhist Reincarnation in religion and Revolution. By Owen Lattimore.

and Fujiko Isono. Asiatische forschungen. band 74. Otto Harrassowitz. Wiesbaden p.162.

5.О.Латимор Нүүдэлчид ба хувьсгалчид. УБ., 1994. 123 дахь тал.

6.ОУМСХ-ны Монгол судлалын мэдээлэл "Бюллетень" 1990, №2 /6/. 50,52 дахь тал.